БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## БАЯН-АГТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**Аудитын код: БУА-2023/114/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган аймаг<br>2023 он | Аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ<br>Утас: 70342580 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:<br>Баталгаат тооцоолол аудит ХХК<br>Захирал: М.Буянбулган<br>Утас: 99053144 Цахим хаяг: buyanbulgan@batalgaattaudit.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА


1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5

3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 10

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 10

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..... 11

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 11

3.4Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд 12

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 12

4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 13

4.1 Ерөнхий зүйл ..... 13

4.2 Материаллаг байдал ..... 13

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 13

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .. 14

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 14

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 14

4.5.1 Завсрын аудитын талаар ..... 14

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 15

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 15

5.1 Төлбөрийн акт ..... 15

5.2 Албан шаардлага ..... 15

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 15


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Аньдагчдын орон чолоо 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 126

таний ______ ны № ______ т

БАЯН-АГТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ОТГОНЦЭЦЭГ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Агт сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

2022 оны эцэст цэцэрлэгийн эрхлэгч тушаал гаргаж тооллогын комисс томилоогүйгээс санхүүгийн тайланд тусгагдсан 4 дансны 73,232.1 мянган төгрөгийн бараа, 6 дансны 455,924.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нийт 529,156 мянган төгрөгийн хөрөнгөд тооллого хийсэн нь нотлогдохгүй байна. Бидний тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшин 3,388,6 мянган төгрөгөөс давсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хуулийн 5.1.4, 13.1, 13.6, 19.1, 20.1.4, 20.2.4 заалтуудыг хэрэгжүүлээгүйтэй холбоотой бөгөөд санхүүгийн тайлагналын үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

2022 онд Боловсролын салбарт төсвийн шинэчлэл хийгдсэнээс улсын төсвөөс 282,380.7 мянган, орон нутгийн төсвөөс 72,686.1 мянган нийт 355,066.8

D:/bichighereg/2023A4toot

006020144

мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өнгөрсөн оноос 42,482.2 мянган төгрөгөөр өссөн.

**Аудитын гол асуудал**

Баян-агт сумын Цэцэрлэг нь 2022 онд аймгийн Боловсролын газар болон сумын Засаг даргатай Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг биелэлтийг 85 хувьтай гэж гаргасан боловч аймгийн Боловсролын газар, сумын Засаг даргад дүгнүүлээгүй.

2022 онд тээвэр шатахуунд 327.9 мянган, хүнсний материалын 168.3 мянган, байгууллагад 38.0 мянган нийт 534.2 мянган төгрөгийн төгрөгийн өглөг шинээр үүссэн.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.ЭРДЭНЭ

D:/bichighereg/2023A4toot

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **66,820,233.29** | **78,302,804.23** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 0.00 | 5,070,722.49 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 0.00 | 5,070,722.49 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 66,820,233.29 | 73,232,081.74 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,827,950.00 | 1,766,550.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 61,510,426.04 | 63,379,876.04 |
| 35460 | Хүнсний материал | 3,481,857.25 | 8,085,655.70 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **363,561,200.43** | **343,116,284.75** |
| **392** | **Биет хөрөнгө** | 353,100,325.43 | 332,908,534.75 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 329,810,000.00 | 329,810,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (33,252,576.57) | (45,255,668.87) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 53,604,654.00 | 53,604,654.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (26,423,786.59) | (33,354,726.71) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 53,100,952.86 | 55,985,952.86 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (29,548,595.27) | (33,691,353.53) |
| 39217 | Ном | 5,809,677.00 | 5,809,677.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 10,460,875.00 | 10,207,750.00 |
| 39301 | Програм хангамж | 1,350,000.00 | 1,350,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (253,125.00) | (506,250.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,364,000.00 | 9,364,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **430,381,433.72** | **421,419,088.98** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 0.00 | **534,250.20** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 0.00 | 534,250.20 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.00 | 496,250.20 |
| **4136** | **Бусад өглөг** | 0.00 | 38,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 0.00 | 38,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **430,381,433.72** | **420,884,838.78** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 430,381,433.72 | 420,884,838.78 |
| 51101 | Өмч: - төрийн | 95,616,502.48 | 95,616,502.48 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (19,511,521.54) | (29,008,116.48) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (19,511,521.54) | (19,511,521.54) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | (9,496,594.94) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 354,276,452.78 | 354,276,452.78 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **430,381,433.72** | **421,419,088.98** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **319,822,840.00** | **357,763,550.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **7,992,040.00** | **2,696,750.00** |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 7,992,040.00 | 2,696,750.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **311,830,800.00** | **355,066,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **256,448,400.00** | **282,380,700.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 0.00 | 282,380,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 256,448,400.00 | 0.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **200,000.00** | **0.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 200,000.00 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **55,182,400.00** | **72,686,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 55,182,400.00 | 72,686,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **323,586,298.23** | **367,260,144.94** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **323,586,298.23** | **367,260,144.94** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **303,444,246.05** | **365,112,645.94** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **187,021,173.00** | **217,538,256.00** |
| 210101 | Үндсэн цалин | 134,122,995.00 | 168,561,248.00 |
| 210102 | Нэмэгдэл | 37,010,017.00 | 42,205,281.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 24,498.00 |
| 210104 | Урамшуулал | 15,888,161.00 | 6,102,691.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 644,538.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **24,340,570.60** | **30,729,747.51** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,289,836.32 | 20,727,284.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,585,629.57 | 2,501,215.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,889,239.25 | 2,000,072.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 319,633.32 | 500,443.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,256,232.14 | 5,000,731.50 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **54,382,400.00** | **55,256,275.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,253,301.00 | 2,190,213.00 |
| 210302 | Түлш, халаалт | 52,919,099.00 | 52,916,062.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 210,000.00 | 150,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **3,012,799.25** | **0.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 317,500.00 | 0.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,264,999.25 | 0.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 437,000.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 910,500.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 82,800.00 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **7,499,275.55** | **28,404,551.55** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 27,800.00 | 0.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,450,775.55 | 28,404,551.55 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,020,700.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **0.00** | **990,300.00** |
| 210604 | Урсгал засвар | 0.00 | 990,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **99,100.00** | **0.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 99,100.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **154,100.00** | **592,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 154,100.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 592,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 26,934,827.65 | 31,601,515.88 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,276,480.75 | 6,836,045.20 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,018,450.00 | 1,435,555.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 21,639,896.90 | 23,329,915.68 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **20,142,052.18** | **2,147,499.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **600,000.00** | **0.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | 0.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **19,542,052.18** | **0.00** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,542,052.18 | 0.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 0.00 | 2,147,499.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 2,147,499.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(3,763,458.23)** | **(9,496,594.94)** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(3,763,458.23)** | **(9,496,594.94)** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **312,581,550.00** | **355,066,800.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **750,750.00** | 0.00 |
| 120009 | Бусад орлого | 750,750.00 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **311,830,800.00** | **355,066,800.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 256,448,400.00 | 282,380,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 0.00 | 282,380,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 256,448,400.00 | 0.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 200,000.00 | 0.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 200,000.00 | 0.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **55,182,400.00** | **72,686,100.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 55,182,400.00 | 72,686,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **305,821,850.00** | **348,586,077.51** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **305,821,850.00** | **348,586,077.51** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **285,679,797.82** | **346,438,578.51** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 187,146,177.22 | 217,538,256.00 |
| 210101 | Үндсэн цалин | 134,247,999.22 | 168,561,248.00 |
| 210102 | Нэмэгдэл | 37,010,017.00 | 42,205,281.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 24,498.00 |
| 210104 | Урамшуулал | 15,888,161.00 | 6,102,691.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 644,538.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **24,340,570.60** | **30,729,747.51** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,480,696.32 | 20,727,284.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,585,629.57 | 2,501,215.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 698,379.25 | 2,000,072.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 319,633.32 | 500,443.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,256,232.14 | 5,000,731.50 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **54,382,400.00** | **55,256,275.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,250,000.00 | 2,190,213.00 |
| 210302 | Түлш, халаалт | 52,922,400.00 | 52,916,062.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 210,000.00 | 150,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,605,900.00** | **0.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 462,500.00 | 0.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,265,000.00 | 0.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 467,000.00 | 0.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,221,600.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 189,800.00 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **9,227,250.00** | **32,960,000.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 48,800.00 | 0.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,715,250.00 | 32,960,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 463,200.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **800,000.00** | **990,300.00** |
| 210604 | Урсгал засвар | 800,000.00 | 990,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **99,100.00** | **0.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 99,100.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **446,700.00** | **592,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 446,700.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 592,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,631,700.00 | 8,372,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,027,900.00 | 5,672,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,603,800.00 | 2,700,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **20,142,052.18** | **2,147,499.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 600,000.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 600,000.00 | 0.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 19,542,052.18 | 0.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 19,542,052.18 | 0.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 0.00 | 2,147,499.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 2,147,499.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **6,759,700.00** | **6,480,722.49** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **6,759,700.00** | **1,410,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 6,759,700.00 | 1,410,000.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 1,869,700.00 | 0.0 |
| 223001 | Бусад хөрөнгө | 4,890,000.00 | 1,410,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(6,759,700.00)** | **(1,410,000.00)** |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | 0.00 | 0.00 |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.00 | 5,070,722.49 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 0.00 | 0.0 |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.00 | 5,070,722.49 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **95,616,502.48** | **354,276,452.78** | **(19,511,521.54)** | **430,381,433.72** |
| D01 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **95,616,502.48** | **354,276,452.78** | **(19,511,521.54)** | **430,381,433.72** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **95,616,502.48** | **354,276,452.78** | **(19,511,521.54)** | **430,381,433.72** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | (9,496,594.94) | (9,496,594.94) |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **95,616,502.48** | **354,276,452.78** | **(29,008,116.48)** | **420,884,838.78** |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | Хувь |
|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **352,752,800.00** | **349,996,077.51** | **99** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **352,752,800.00** | **348,586,077.51** | **99** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **352,752,800.00** | **346,438,578.51** | **98** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **221,913,500.00** | **217,538,256.00** | **98** |
| 210101 | Үндсэн цалин | 176,319,500.00 | 168,561,248.00 | 96 |
| 210102 | Нэмэгдэл | 42,416,600.00 | 42,205,281.00 | 100 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 24,498.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 3,177,400.00 | 6,102,691.00 | 192 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 644,538.00 | 0.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **31,425,300.00** | **30,729,747.51** | **98** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,049,300.00 | 20,727,284.39 | 98 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,594,600.00 | 2,501,215.81 | 96 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,075,100.00 | 2,000,072.65 | 96 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 518,800.00 | 500,443.16 | 96 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,187,500.00 | 5,000,731.50 | 96 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **55,280,000.00** | **55,256,275.00** | **100** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,200,000.00 | 2,190,213.00 | 100 |
| 210302 | Түлш, халаалт | 52,930,000.00 | 52,916,062.00 | 100 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 150,000.00 | 150,000.00 | 100 |
| **2105** | **Нормативт зардал** | **32,960,000.00** | **32,960,000.00** | **100** |
| 210502 | Хоол, хүнс | 32,960,000.00 | 32,960,000.00 | 100 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **800,000.00** | **990,300.00** | **124** |
| 210604 | Урсгал засвар | 800,000.00 | 990,300.00 | 124 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **592,000.00** | **592,000.00** | **100** |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 592,000.00 | 592,000.00 | 100 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **9,782,000.00** | **8,372,000.00** | **86** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,082,000.00 | 5,672,000.00 | 80 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,700,000.00 | 2,700,000.00 | 100 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **0.00** | **2,147,499.00** | **0.00** |
| 213304 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 2,147,499.00 | 0.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **0.00** | **1,410,000.00** | **0.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | 0.00 | 1,410,000.00 | 0.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **352,752,800.00** | **355,066,800.00** | **100** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **282,380,700.00** | **282,380,700.00** | **100** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 282,380,700.00 | 282,380,700.00 | 100 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 70,372,100.00 | 72,686,100.00 | 103 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **0.00** | **5,070,722.49** | **0.00** |

## 3.САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баян-Агт сумын цэцэрлэг нь Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд сургуулийн өмнөх боловсролын зорилгыг бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино гэж чиг, үүргийг хуулийн 5.1, 5.2, 5.3 заалтад тодорхойлжээ.

2022 онд аймгийн Боловсролын газар болон сумын Засаг даргатай Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 9 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, батлуулсан ба гүйцэтгэлийг 97.5 хувийн биелэлтэйгээр тайлагнасныг сумын Засаг дарга хүлээн зөвшөөрч баталгаажуулсан байна.

2022 онд Боловсролын салбарт төсвийн шинэчлэл хийгдснээс улсын төсвөөс 282,380.7 мянган, орон нутгийн төсвөөс 72,686.1 мянган нийт 355,066.8 мянган төгрөгийн санхүүжилт авсан нь өнгөрсөн оноос 42,482.2 мянган төгрөгөөр өссөн. 120 хүүхдийн цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн зураг төсвийг 2023 оны улсын төсвийн жагсаалтад тусгуулсан.

Баян-агт сумын Цэцэрлэг нь 2022 онд аймгийн Боловсролын газар болон сумын Засаг даргатай Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2 зорилтын хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг биелэлтийг 85 хувьтай гэж гаргасан боловч аймгийн Боловсролын газар, сумын Засаг даргад дүгнүүлээгүй.

2022 онд тээвэр шатахуунд 327.9 мянган, хүнсний материалын 168.3 мянган, байгууллагад 38.0 мянган нийт 534.2 мянган төгрөгийн төгрөгийн өглөг үүссэн.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баян-Агт сумын цэцэрлэг нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон дараах бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай”;
- Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоол “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай”;
- Сангийн сайд, Монгол банкны Ерөнхийлөгчийн 2022 оны А122/А-172 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Засгийн газар болон төсвийн байгууллагын дансыг банканд нээх, хаах, тайлагнах журам”;
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай”,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;
- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй тул дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Агт сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Санхүүгийн үйл ажиллагаандаа ашигладаг Си Ти Эс програм ашигладаг.

**3.4Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Баян-Агт сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн ба тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,962.3 мянган төгрөг буюу 2.1 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 5,070.7 | 5,070.7 |
| Бараа материал | 66,820.2 | 73,232.1 | 6,411.9 |
| Үндсэн хөрөнгө | 363,561.2 | 343,116.3 | -20,444.9 |
| **Нийт хөрөнгө** | **430,381.4** | **421,419.1** | **-8,962.3** |
| Өр төлбөр | | 534.3 | 534.3 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | **430,381.4** | 420,884.8 | -9,496.6 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **430,381.4** | **421,419.1** | **-8,962.3** |

Хүснэгтээс дэх 2022 оныг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулж гарсан өөрчлөлтийг судлан үзэхэд салбарын бодлогын шинэчлэлтэй холбоотой мөнгөн хөрөнгө 5,070.7 мянган, төгрөгөөр шилжүүлэн авсан 1,221.7 мянган, аж ахуйн зориулалтаар худалдан авсан барааны үлдэгдэл нь бараа материалыг 6,411.9 мянган төгрөгөөр өсгөж, тайлант онд 23,329.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгууллагдсан нь үндсэн хөрөнгийг 20,444.9 мянган төгрөгөөр буурахад нөлөөлсөн ба тээвэр шатахуунд 327.9 мянган, хүнсний материалын 168.3 мянган, байгууллагад 38.0 мянган нийт 534.2 мянган төгрөгийн төгрөгийн өглөг үүссэн байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг нийт 513,3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 158.2 сая төгрөгөөр бууруулж, 355.1 сая төгрөгөөр баталсан байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 282.4 сая, орон нутгийн төсвөөс 72.7 сая төгрөгөөр баталсан байна. Зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 98.6 хувийн биелэлттэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Агт сумын цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Төсвийг зохистой удирдаж, зориулалтын дагуу зарцуулах, эд хариуцагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулах талаар болон Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөлүүдийг тусгасан болно.

Баян-Агт сумын цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баталгаат тооцоолол аудит ХХК-д 2023  оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

Аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК-ийн аудитор Н.Цэнгэнбаяр, дотоод хяналтыг аудитын менежер Г.Батбаяр гүйцэтгэж, захирал М.Буянбулган хянан удирдаж, аудитын ажлын үе шатны болон гол хяналтуудыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар хэрэгжүүлэв

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд байгууллагын орлогын эх үүсвэр нь улсын төсөв болон үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрддэг тул 2022 оны батлагдсан төсвийн  нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тооцож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг Дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан батлагдсан төсвийн нийт зардлын суурь үзүүлэлтээс 1.5 хувиар буюу 4,235,7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

` Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан   хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан дэд дарга, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 8 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор цалин хөлс болон нэмэгдэл урамшууллыг 8,188.6 мянган, тогтмол зардлыг 17,429.8 мянган, бараа үйлчилгээний бусад зардлыг 4,110.0 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус цэцэрлэг 2022 онд шилэн дансны сайтад 148 мэдээлэл байршуулахаас 144 мэдээллийг хугацаанд нь оруулснаар байршуулсан. Тулган шалгалтаар 2 нь хугацаа болоогүй, хоосноор 2, хугацаа хоцроосон 6, төсөв, Хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой эрхлэгчийн 2022 оны А 3-н, Б 23 тушаалыг шилэн дансанд оруулаагүй. Үүнд: нийт 14,782.2 мянган төгрөгийн 10, мөнгөн дүнгүй 13 тушаал байна. Мөн мэдээллийг буруу оруулсан. Тухайлбал 5 сард 5 саяас дээш гүйлгээ байхгүй гэсэн байв.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Аудитын байгууллагын сонгон шалгаруулалтын хугацаанаас хамаарч завсрын аудит хийх боломжгүйд хүргэсэн. Аудитын нээлтийг 2022 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 10 цагаас цахимаар эхлүүлж, аудит хийх мэдэгдэл, аудитад ирүүлэх баримтын мэдээллийн жагсаалтыг цахимаар болон биечлэн хүргүүлж, байгууллагуудын эхний хагас жилийн санхүүгийн тайланд судалгаа хийж, 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан, өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт, байгууллагын талаарх мэдээлэлтэй танилцан аудитын төлөвлөлтийн үе шатны ажлыг гүйцэтгэв.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн бөгөөд хэрэгжилтийг 2022 оны 6 дугаар сарын 28-ны 09/09 тоотоор зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь ТАГ-т хүргүүлжээ.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | **1** | 1,452.2 | **1** | 1,452.2 | 100.0 |
| Албан шаардлага | 2 | 6,759.7 | 2 | 6,759.7 | 100.0 |
| Зөвлөмж | 2 | 14,400.0 | 2 | 14,400.0 | 100.0 |
| **Нийт дүн** | **5** | **22,611.9** | **5** | **22,611.9** | 100.0 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн зөвлөмж болон хүргүүлсэн асуудлуудын хэрэгжилт завсрын аудитыг гүйцэхэд анхаарна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар батламж мэдэгдлийн хүрээнд нийт 473,024.0 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 41,893.4 мянган төгрөгийн алдааг залруулж, эрх зүйн акт зөрчигдсөн[2] алдааг дахин давтан гаргахгүй байх 3 албан шаардлага өгөв.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар жилийн эцсийн тооллогыг эрхлэгчийн тушаалаар комисс томилж хийгээгүй, агуулахын бүртгэлийг нягтлан бодогч хянан баталгаажуулдаггүй, цагийн бүртгэлийг анхан шатны баримтын дагуу бүртгээгүй, Шилэн дансны хууль, журмыг мөрдлөг болгон ажиллаагүйд албан шаардлага өгөв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Залруулга | 1 | 41,893.4 | | | | | 1 | 41,893.4 | | | 1 | 41,893.4 |
| Дүн | 1 | 41,893.4 | | | | | 1 | 41,893.4 | | | 1 | 41,893.4 |

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс Төлбөрийн акт | | Үүнээс Албан шаардлага | | Үүнээс Зөвлөмж | | Үүнээс Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Үүнээс Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Эрх зүйн актыг мөрдөөгүй | 3 | 431,130.6 | | | 3 | 431,130.6 | | | | | | |
| Дүн | 3 | 431,130.6 | | | 3 | 431,130.6 | | | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл